



XI/2021


Тархаасан: 2021 оны 12 дугаар сарын 13



Үнэмлэхүй их температур 2021 оны 11 дүгээр сард Өмнөговь аймгийн Манлай суманд +18.0 °C-д хүрсэн байна

Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 11 дүгээр сард Өмнөговь аймгийн Манлай суманд +18.0°C, үнэмлэхүй бага температур Баян-Өлгий аймгийн Сагсай суманд -34.0°C-д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР (°C), олон жилийн дундажтай¹ харьцуулснаар, станцын байршлаар, жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар



¹ - Сүүлийн 30 жил

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2021 оны 11 дүгээр сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр хэмжээ Увс аймгийн Малчин суманд 15.2 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Ховд аймгийн Зэрэг суманд 33 м/с-д хүрсэн байна.

Агаарын чанар

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын хамгийн их агууламж 2021 оны 11 дүгээр сард Мишээл экспо төв, Богд хааны ордон музей, Хархорин зах, 13-р хороолол, Ургах наран хороолол, 32-ын тойрог, Хайлааст, Нисэх, 248-р цэцэрлэг, Зурагт, 1-р хороолол, Амгалан орчимд 0.054мг/м³-0.419 мг/м³ -д хүрч, агаарын чанарын хүлцэх агууламжаас 0.004 мг/м³-0.369 мг/м³-ээр давсан байна.


Азотын давхар ислийн сарын хамгийн их агууламж 2021 оны 11 дүгээр сард Хайлааст, Ургах наран хороолол, Нисэх, Богд хааны ордон музей, 248-р цэцэрлэг, Амгалан, 13-р хороолол, 1-р

хороолол, Баруун дөрвөн зам, Хархорин зах орчимд 0.057 мг/м³-0.181 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.007 мг/м³-0.131 мг/м³-ээр давсан байна.

Харин PM 10 тоосонцрын сарын хамгийн их агууламж 2021 оны 11 дүгээр сард Богд хааны ордон музей, Зурагт, 248-р цэцэрлэг, 13-р хороолол, Толгойт, 32-ын тойрог, Баруун дөрвөн зам, Ургах наран хороолол, 1-р хороолол, Хайлааст, Нисэх, Хархорин зах, Баянхошуу орчимд 0.106 мг/м³ – 0.414 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.006 мг/м³ – 0.314 мг/м³-ээр давсан байна.

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 2021 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 0.016 мг/м³ (20.2%)-ээр, азотын давхар ислийн дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.018 мг/м³ (48.8%)-ээр, PM 10 тоосонцрын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.033 мг/м³ (33.9%)-ээр, PM 2.5 тоосонцрын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.015 мг/м³ (30.3%)-аар тус тус их байна.

ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар, мг/м³



Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2021 оны эхний 11 сард 3640 болж, өмнөх оны мөн үеэс 209 (5.4%) -өөр буурсан байна. Газар хөдлөлт 2021 оны эхний 11 сард 269 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 215 (5.0 дахин)-аар нэмэгдсэн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 11 сарын байдлаар нийт 301 хүн амь насаа алдаж, өмнөх оны мөн үеэс 61 (25.4%)-ээр нэмэгдсэн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 11 сарын байдлаар 22.5 тэрбум төгрөгийн хохирол учирч, 1.2 тэрбум төгрөг зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ², жил бүрийн эхний 11 сарын байдлаар

Үзүүлэлт	2018 I-XI	2019 I-XI	2020 I-XI	2021 I-XI	2021 I-XI 2020 I-XI
					хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	4 337	4 681	3 849	3 640	94.6
Газар хөдлөлтийн тохиолдлын тоо	32	39	54	269	5.0 ¹
Объектын түймрийн тоо	3 455	3 908	2 919	2 392	81.9
Амь насаа алдсан хүний тоо	195	202	240	301	125.4
Учирсан хохирол, тэрбум төгрөг	39.8	48.7	108.2	22.5	20.8
Зарцуулсан зардал, тэрбум төгрөг	10.2	1.1	0.3	1.2	4.0 ¹

¹ - Дахин их

² - Корона вируст халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол

Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл

Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг

Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин

Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж

Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



Эх үүсвэр:

Цаг Уур, Орчны Шинжилгээний Газар
Онцгой Байдлын Ерөнхий Газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 01 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн
статистикийн хэлтсийн ахлах статистикч
Б.Уянгаа
Утас : (976-51)-261563

